

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийгдсэн тайлан	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УЛС ХООРОНДЫН ШУУДАН
ИЛГЭЭМЖИЙН ГААЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.МЯГМАР ТАНАА

2019.02.25 № 06/224
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын дарга Б.Мягмар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Тэд-Аудит” ХХК-ийн аудитор Г.Эрдэнэчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газар-т 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/34 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар нь Хууль ёсны худалдааг хөнгөвчилж, эдийн засгийн өсөлтийг дэмжих гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон.

Үйл ажиллагааны чиглэл:

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар нь 2018 оныг Дэлхийн гаалийн байгууллагаас “Эдийн засгийн хөгжилд хөтлөх бизнесийн аюулгүй орчин”, Гаалийн ерөнхий газраас дэвшүүлсэн “Хууль ёсны худалдааг хөнгөвчилж, эдийн засгийн өсөлтийг дэмжих” зорилтын хүрээнд 2018 онд улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, төрийн эдийн засаг нийгмийн бодлогын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ гаалийн байгууллагын ажлыг илүү нээлттэй, ард иргэдэд чирэгдэлгүй үйлчилдэг болгох, иргэд бизнес эрхлэгчдээс гаалийн бүрдүүлэлтийн явцад зарцуулах цаг хугацаа, зардлыг багасгах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс шуудангийн үйлчилгээгээр бизнес, худалдааны үйл ажиллагаа явуулахад тааламжтай нөхцлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллажээ.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “**Бага**” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод

хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлын 1 хувиар сонгов.

2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь АОУС 320-ын дагуу тодорхойлсонтой холбоотой юм.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 1,234,634.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 12,346.34 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь байгууллагын хамрах хүрээ хязгаарлагдмал, санхүүжилтийн хэмжээ бага, өөрийн орлого байхгүй, гарч болох эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцов.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	0.00	
	Дүн	3	0.00	

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын санхүүгийн тайлангийн иж бүрдэл хэсгүүдийг УСНББОУС-ын дагуу үнэн зөв, бодитой гаргахад чиглэсэн горим сорилыг хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотойгоор тайлант жилд нийт 1,165,467.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,165,447.1 мянган төгрөгийг зарцуулж 20.6 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн тайлагналын талаар

3.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн тодруулга хагас дутуу хийж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт болон АОУС 700-ын 14 (а, б) дэх зүйлд заасан “Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга”-ыг үнэлэх боломжгүй болгож байна.

3.1.2 Эрсдэл:

УСНББОУС-1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчих, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн дутуу байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн тодруулгыг УСНББОУС 1-ын шаардлага, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан тодруулгын зааврын дагуу бүрэн гаргаж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засч залруулж ажиллах болно.

3.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын дагуу 2.3, 2.5-д заасны дагуу Төсөвт байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг маягтын дагуу үнэн зөв гаргаж баталгаажуулахаар заасны дагуу зөв гаргахгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

“Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын дагуу 2.3, 2.5-д заасны дагуу Төсөвт байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг үнэн зөв гаргаж санхүүгийн тайланд хавсаргаж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засч залруулж ажиллах болно.

3.3 Бараа материалын талаар

3.3.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайланг нярав агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл, тоо хэмжээгээр нэгтгэн сар бүр гаргадаггүй, түүнд нягтлан бодогч хяналт тавьж, баталгаажуулахгүй байна. (Бичиг хэргийн материал, шатах тослох материал, хангамжийн материал гэх мэт) Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Маягт, заавар батлах тухай” журмыг зөрчиж байна.

3.3.2 Эрсдэл:

Бараа материалын тайланг холбогдох журмын дагуу гаргаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Маягт, заавар батлах тухай” журмаар батлагдсан бараа материалын тайлан гаргах маягтуудыг загварын дагуу бөглөж, бараа материалын тайланг сар бүр гаргаж, хяналт тавьж байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг засч залруулж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,354,628.45</u>	<u>29,011,099.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	20,600.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	20,600.00
31110	Төгрөг	-	20,600.00
33	АВЛАГА	-	1,234,125.54
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	397,452.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага		397,452.00
335	Бусад авлага	-	439,221.54
3351	Байгууллагаас авах авлага		439,221.54
336	Зээлийн авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	2,007,577.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	2,007,577.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	19,354,628.45	25,748,796.86
351	Түүхий эд материал	77,000.00	374,000.00
35110	Тусгай зориулалттай материал	77,000.00	374,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	197,500.00	197,500.00
354	Хангамжийн материал	19,080,128.45	25,177,296.86
35410	Бичиг хэргийн материал	947,350.00	6,270,407.51
35420	Аж ахуйн материал	8,855,047.03	10,131,807.03
35430	Сэлбэг хэрэгсэл	665,700.00	3,691,700.00
35440	Түлш, шатах тослох материал	-	304.00
35470	Бусад хангамжийн материал	8,612,031.42	5,083,078.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>275,537,305.30</u>	<u>294,057,455.56</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	275,537,305.30	294,057,455.56
392	Биет хөрөнгө	275,537,305.30	294,057,455.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,234,000.00	129,234,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-80,122,888.98	-60,609,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	573,142,776.40	435,831,094.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-330,799,163.62	-218,267,952.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,691,880.83	31,522,509.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,609,299.33	-23,653,196.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,568,164.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,568,164.00	-
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>294,891,933.75</u>	<u>323,068,554.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>31,292.49</u>	<u>1,034,960.58</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	31,292.49	1,034,960.58
413	Өглөг	31,292.49	1,034,960.58
4136	Бусад өглөг	31,292.49	1,034,960.58
41361	Байгууллагад төлөх өглөг	31,292.49	1,034,960.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>294,860,641.26</u>	<u>322,033,594.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	294,860,641.26	322,033,594.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	264,349,638.94	264,349,638.94
51101	Өмч: - төрийн	264,349,638.94	264,349,638.94
512	Хуримтлагдсан үр дүн	30,510,604.32	57,683,557.44
51210	Өмнөх үеийн үр дүн	30,510,604.32	30,510,604.32
51220	Тайлант үеийн үр дүн	-	27,172,953.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398.00	398.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>294,891,933.75</u>	<u>323,068,554.96</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,231,259,809.15	1,261,806,507.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,477,109.15	9,641,620.00
120	Нийтлэг татварын бус орлого	200,477,109.15	9,641,620.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,477,109.15	9,641,620.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	200,477,109.15	9,641,620.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,030,782,700.00	1,252,164,887.69
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,030,782,700.00	1,165,467,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,030,782,700.00	1,165,467,700.00
1330	Төсвийн захирагчдаас	-	86,697,187.69
133003	Хөрөнгийн	-	86,697,187.69
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,084,538,976.86	1,206,936,915.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,084,538,976.86	1,206,936,915.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,084,499,839.86	1,176,339,701.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	900,943,692.75	961,356,105.04
210101	Үндсэн цалин	864,326,758.75	465,694,406.00
210102	Нэмэгдэл	2,301,734.00	378,845,689.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,315,200.00	24,974,400.00
210104	Урамшуулал		91,841,610.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,855,208.74	116,425,880.00
210201	Тэтгэврийн даатгал	87,855,208.74	86,742,000.00
210202	Тэтгэмжийн даатгал		7,947,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		6,358,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,589,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал		13,788,480.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,754,900.00	15,731,926.00
210301	Гэрэл, цахилгаан	1,354,900.00	1,331,926.00
210304	Байрны түрээс	14,400,000.00	14,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,781,060.00	18,498,678.50
210401	Бичиг хэрэг	1,048,700.00	3,091,148.00
210402	Тээвэр, шатахуун	6,788,500.00	8,588,596.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	643,860.00	518,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	199,200.00
210408	Бараа материал акталсны зардал	-	6,101,434.50
2105	Нормативт зардал	805,695.00	-
210502	Хоол, хүнс	805,695.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,478,500.00	4,730,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	249,500.00	630,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	863,500.00	
210604	Урсгал засвар	2,365,500.00	4,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,185,921.06	17,550,463.60

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,297,000.00	520,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,200,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,290,032.00	138,453.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		150,532.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	130,000.00	250,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,268,889.06	10,491,278.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,694,862.31	42,046,648.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	441,000.00	300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,253,862.31	41,746,648.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,137.00	30,597,214.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,137.00	30,597,214.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,137.00	30,597,214.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>146,720,832.29</u>	<u>54,869,592.29</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,489,631.25	27,696,639.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,110,031.25	27,600,389.17
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,379,600.00	96,250.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,489,631.25)	(27,696,639.17)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>135,231,201.04</u>	<u>27,172,953.12</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,030,786,900.00	1,165,467,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,030,786,900.00	1,165,467,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,030,786,900.00	1,165,467,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,030,782,700.00	1,165,467,700.00
300001	Нэр данс зөрүүтэй орлого	4,200.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,030,786,900.00	1,165,447,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,030,786,900.00	1,165,447,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,747,763.00	1,134,849,886.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869,163,109.00	961,559,470.00
210101	Үндсэн цалин	505,710,230.00	465,694,406.00
210102	Нэмэгдэл	264,278,479.00	378,845,689.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,974,400.00	24,974,400.00
210104	Урамшуулал	74,200,000.00	92,044,975.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,608,700.00	116,425,880.00
210201	Тэтгэврийн даатгал	98,608,700.00	86,742,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	7,947,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	6,358,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,589,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	13,788,480.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,754,900.00	15,731,926.00
210301	Гэрэл, цахилгаан	1,354,900.00	1,331,926.00
210304	Байрны түрээс	14,400,000.00	14,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,154,072.00	12,089,348.00
210401	Бичиг хэрэг	1,378,700.00	2,623,148.00
210402	Тээвэр, шатахуун	6,788,500.00	8,588,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	686,872.00	508,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	369,000.00
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,618,200.00	10,399,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,455,200.00	3,399,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	863,500.00	-
210604	Урсгал засвар	2,299,500.00	7,000,000.00
2107	Томилот, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,007,782.00	18,343,762.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,374,000.00	2,597,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,200,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,139,200.00	2,146,030.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,832.00	150,532.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	246,000.00	250,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,897,750.00	7,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	441,000.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	441,000.00	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,039,137.00	30,597,214.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,000,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,137.00	30,597,214.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,137.00	30,597,214.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>20,600.00</u>
4	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
5	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	20,600.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	264,349,638.94			264,349,638.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн				0.00
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,349,638.94	0.00	0.00	264,349,638.94
2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	264,349,638.94	0.00	0.00	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		398.00	30,510,604.32	30,511,002.32
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		398.00	30,510,604.32	30,511,002.32
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			27,172,953.12	27,172,953.12
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,349,638.94	398.00	57,683,557.44	322,033,594.38

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү (+, -)	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,165,467,700.00	1,165,447,100.00	20,600.00	100
УРСГАЛ ЗАРДАЛ	1,165,467,700.00	1,165,447,100.00	20,600.00	100
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,165,467,700.00	1,134,849,886.00	30,617,814.00	97
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,774,400.00	961,559,470.00	26,214,930.00	97
Үндсэн цалин	469,521,500.00	465,694,406.00	3,827,094.00	99
Нэмэгдэл	393,278,500.00	378,845,689.00	14,432,811.00	96
Унаа хоолны хөнгөлөлт	24,974,400.00	24,974,400.00	-	100
Урамшуулал	100,000,000.00	92,044,975.00	7,955,025.00	92
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,532,900.00	116,425,880.00	2,107,020.00	98
Тэтгэврийн даатгал	86,742,000.00	86,742,000.00	-	100
Тэтгэмжийн даатгал	7,947,700.00	7,947,700.00	-	100
ҮОМШӨ-ний даатгал	6,358,200.00	6,358,200.00	-	100
Ажилгүйдлийн даатгал	1,589,500.00	1,589,500.00	-	100
Эрүүл мэндийн даатгал	15,895,500.00	13,788,480.00	2,107,020.00	87
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,759,300.00	15,731,926.00	27,374.00	100
Гэрэл, цахилгаан	1,354,900.00	1,331,926.00	22,974.00	98
Байрны түрээс	14,404,400.00	14,400,000.00	4,400.00	100
Хангамж, бараа материалын зардал	12,095,900.00	12,089,348.00	6,552.00	100
Бичиг хэрэг	2,629,700.00	2,623,148.00	6,552.00	100
Тээвэр, шатахуун	8,588,900.00	8,588,900.00	-	100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	508,300.00	508,300.00	-	100
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			-	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	369,000.00	369,000.00	-	100
Аж ахуйн материал худалдан авах зардал			-	
Нормативт зардал	-	-	-	
Эд хогшил, урсгал засварын зардал	10,400,000.00	10,399,500.00	500.00	100
Багаж, техник, хэрэгсэл	3,400,000.00	3,399,500.00	500.00	100
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			-	
Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00	-	100
Томилолт, зочны зардал	-	-	-	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,605,200.00	18,343,762.00	2,261,438.00	89
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,545,000.00	2,597,000.00	1,948,000.00	57
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,020,200.00	6,000,000.00	20,200.00	100

Даатгалын үйлчилгээ	2,426,200.00	2,146,030.00	280,170.00	88
Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00	150,532.00	13,068.00	92
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,200.00	250,200.00	-	100
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,200,000.00	7,200,000.00	-	100
Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00	-	100
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00	-	100
Төвлөрүүлэх шилжүүлэг		30,597,214.00	-30,597,214.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,165,467,700.00	1,165,467,700.00	-	100
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	1,165,467,700.00	-1,165,467,700.00	
Улсын төсвөөс санхүүжих	-	1,165,467,700.00	-1,165,467,700.00	
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,165,467,700.00	-	1,165,467,700.00	0
Орон нутгийн төсвөөс	1,165,467,700.00	-	1,165,467,700.00	0

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2019/357/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар	Мянган төгрөгөөр
------------------------------	---	------------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын тайланг нярав агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл, тоо хэмжээгээр нэгтгэн сар бүр гаргадаггүй, түүнд нягтлан бодогч хяналт тавьж, баталгаажуулахгүй байна. (Бичиг хэргийн материал, шатах тослох материал, хангамжийн материал гэх мэт) Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Маягт, заавар батлах тухай” журмыг зөрчиж байна.		Зөвлөмж өгсөн	Дарга Ахлах ня-бо	Б.Мягмар Ү.Чимэддулам
2	Санхүүгийн тайлангийн тодруулгыг хагас дутуу хийж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт болон АОУС 700-ын 14 (а, б) дэх зүйлд заасан “Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга”-ыг үнэлэх боломжгүй болгож байна.		Зөвлөмж өгсөн	Дарга Ахлах ня-бо	Б.Мягмар Ү.Чимэддулам
3	Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын дагуу 2.3, 2.5-д заасны дагуу Төсөвт байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг маягтын дагуу үнэн зөв гаргаж баталгаажуулахаар заасны дагуу зөв гаргахгүй байна.		Зөвлөмж өгсөн	Дарга Ахлах ня-бо	Б.Мягмар Ү.Чимэддулам
Нийт дүн		0			

